

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдах болсон шалтгаан нөхцөл

Монгол Улс Вена хотноо 1993 онд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн дэлхий дахины бага хуралд оролцож, улс орнууд хүний эрхийг хангах үндэсний зохих баримт бичиг батлан хэрэгжүүлэх тухай тунхаглалыг дэмжиж, үүрэг хүлээсэн билээ.

Мөн 1998 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хүний эрхийн харилцан ойлголцлын Санамж бичигт Монгол Улсын Засгийн газар гарын үсэг зурж, хүний эрхийг хангах, хамгаалах хүрээнд идэвхтэй ажиллахаа нотолсон.

2000 онд Улаанбаатар хотноо төрийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотойгоор Хүний эрхийн үндэсний бага хурал зохион байгуулж, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээ Монгол Улсын Засгийн газар илэрхийлсэн юм.

Уг санаачлагыг Бага хурал санал нэгтэй хүлээн авч, хөтөлбөрийг нийгмийн зөвшилцлийн үндсэн дээр боловсруулахаар шийдвэрлэснийг Нэгдсэн Үндэстний Байгууллага дэмжиж, хөтөлбөр боловсруулах санхүү техникийн туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

Улмаар Хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний цогц эрх зүйн баримт бичиг батлан хэрэгжүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлагын дагуу “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” –ийг Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор батлан гаргасан.

Хөтөлбөрийн гол зорилго нь ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцааны жам ёсонд нийцүүлэн нийгэм, төрийн байгуулал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, орон нутгийн удирдлагын тогтолцоо, соёл-оюуны зэрэг нийгмийн бүх харилцааг шинэтгэж, төрөөс хүний эрхийг хангах зохион байгуулалт, эрх зүйн баталгааг өргөтгөн, зохистой механизмыг бүрдүүлэх явдал юм.

Үндэсний хөтөлбөр нь 4 бүлэгтэй бөгөөд бүтцийн дагуу авч үзвэл :

1. Хүний эрхийг хангах үндэсний механизмыг бэхжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр
2. Хүний хувийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр
3. Хүний улс төрийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр
4. Нийгэм, соёл, эдийн засгийн эрхийн хүрээнд

Хөтөлбөрийн бүтэц

Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр	I бүлэг Хүний эрх,эрх чөлөөг хангах үндэсний чадавхийг дээшлүүлэх нь	<ul style="list-style-type: none">- Хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага- Хүний эрхийн үндэсний комисс, шүүх, прокурор, өмгөөлөх зэрэг хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд- Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа
	II бүлэг Хүний суурь эрхийг хангах нь	<ul style="list-style-type: none">-Хүний хувийн эрх, эрх чөлөө-Хүний улс төрийн эрх, эрх чөлөө-Хүний эдийн засгийн эрх-Нийгэм соёлын эрх
	III бүлэг Хүний эрхийн талаарх олон улсын гэрээний биелэлт ба мониторинг	<ul style="list-style-type: none">-Хүний эрхийг хангах олон улсын механизмыг ашиглах болон хамтын ажиллагааг хөгжүүлэх-Хүний эрхийн талаарх Монгол Улсын гэрээг хэрэгжүүлэх-Хүний эрхийн талаарх олон улсын гэрээний биелэлтэд тавих хяналт, шинжилгээ,
	IV бүлэг Үндэсний хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, санхүүжилт	<ul style="list-style-type: none">-Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах-Тайлагнах- Санхүүжүүлэх

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо

Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 167 дугаар тогтоолоор Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий хороог Монгол улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулж, хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг баталсан. /Бүтцийг схемээр харуулав/

Хорооны даргаар Монгол Улсын Ерөнхий сайд, Хорооны орлогч даргаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хорооны нарийн бичгийн даргаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажилладаг.

Хороо нь төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон орон тооны бус 30 гишүүнтэй.

Хорооны дүрэмд заасны дагуу 2006 оноос эхлэн яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон тооны бус салбар хороо байгуулж, яам, агентлаг, аймаг, нийслэл дээр сум, дүүргийг нэмбэл нийт 403 салбар хороотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбар хорооны дарга нь яаманд Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагт агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүрэгт тэдгээрийн Засаг дарга байдаг.

Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна. Хуралдааныг жилд хоёроос доошгүй удаа хуралдуулдаг.

Хуралдаанаас тогтоол гаргах ба Хороо шаардлагатай гэж үзсэн асуудлаар зөвлөмж, албан даалгавар гаргаж болно.

Хорооноос гарсан тогтоол, зөвлөмж, албан даалгаврыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж албан тушаалтан биелүүлж явц үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд эргэж хариу мэдэгдэх үүрэгтэй.

Хорооны дүрэмд Хорооны ажлын албаны үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яам гүйцэтгэхээр заасан. Энэ заалтыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтцэд Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 36 дугаар тогтоолын дагуу Үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын албыг байгуулсан.

Ажлын алба нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдаж бүтэц, зохион байгуулалтын нэг нэгж болон ажилладаг ба Хорооноос “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, салбар хороодын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, мэргэжил, арга зүй, техник-зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй.

Хорооны ажлын албыг байгуулан ажилд оруулснаар Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхны тодотгосон төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үндэсний хөтөлбөрийн Хорооны ажил идэвхижиж, Салбар хороод байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн.

Хорооны бүтэц, зохион байгуулалт

Хорооны дарга: Монгол Улсын Ерөнхий сайд	Хорооны ажлыг удирдлагаар хангаж, хорооны шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргах ...
Хорооны орлогч дарга: Хууль зүй, дотоод хэргийн сайд	Хорооны даргын эзгүйд түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх
Хорооны нарийн бичгийн дарга: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Хорооны төсвийг захиран зарцуулах, хорооны ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих
Хорооны гишүүд: Төрийн ба төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 30 гишүүнтэй	-Үндэсний хөтөлбөр, Хорооны шийдвэрийн хэрэгжилтийг төрийн ба төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, нутгийн удирдлагын байгууллагад тэдгээрийн өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүй шалгах -Асуудал боловсруулж хорооны хуралдаанд оруулах, хэлэлцүүлэх -Бусад байгууллагатай харилцахдаа хорооны хуралдааны шийдвэрийг баримтлах -Хорооноос даалгасан асуудлыг хариуцан ажиллаж, түүний үр дүнгийн талаар хорооны хуралдаанд мэдээлэх
Хорооны ажлын алба: Хууль, зүй дотоод хэргийн яамны Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын алба	Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын дэмжлэг тусалцаа үзүүлэх
Салбар хороод: Хороо нь яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар хороотой	Салбар хорооны дарга нь яаманд Төрийн нарийн бичгийн дарга, агентлагт агентлагийн дарга, аймаг нийслэл, сум дүүрэгт Засаг дарга байх ба өөрийн байгууллага болон харьяа нутаг дэвсгэртээ Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн жилийн төсөвтөө тусган, тусгай төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулах

Хүний эрхийг ханган үндэсний хөтөлбөрт мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар тусгасан нь

Мэдээллийн эрх чөлөө нь мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийн нэгдэл юм.

Иргэн бүр мэдээллийн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх бололцоотой байх ёстой бөгөөд иргэнээ мэдээллээр хангах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөл бололцоог бий болгох нь ардчилсан төрийн үүрэг юм.

Сүүлийн жилүүдэд төрөөс иргэний мэдээллийн эрх чөлөөг хангах талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авч байна.

Тухайлбал Төрөөс улсын төсөв болон уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах, төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй болгосон, 2006 онд АТГ байгуулагдаж, төрийн байгууллагуудаас иргэдийг мэдээллээр хангах үүргээ биелүүлэхийг шаардах болсон.

Мөн Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж, үүндээ мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулахаар тусгагдсан зэргийг дурьдаж болно.

Тус хөтөлбөрийн 2 бүлэгт Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах талаар 8 заалт тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2007-2008 оны төлөвлөгөөнд дээрх 8 заалтаас 2 заалт нь тусгагдсан.

2.2.5.4 Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 3 арга хэмжээ тусгагдан. Үүнд:

а/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаархи хууль тогтоомжид хяналт шинжилгээ хийх;

Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газраас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаархи хууль тогтоомжид дүн шинжилгээ хийгээд байна.

б/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж байна

в/ Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд Улсын дээд шүүхээс тайлбар гаргуулах

УДШ-ийн 2007 оны 12 дугаар сарын 21 ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд / Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх / -ийг тайлбарласан.

2.2.5.7 Үндэсний цөөнх эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангана.

Энэ заалтын хүрээнд 2 арга хэмжээ тусгагдсан.

а/ Баян-Өлгий аймгийн радио станцыг шинэчлэн сайжруулах чиглэлээр ажиллах

Баян-Өлгий аймгийн радио өргөн нэвтрүүлгийн станцыг шинэчлэх төсөл"-ийг боловсруулж Баян-Өлгий аймгийн ЗДТГазар, МХХТГазар, Баян-Өлгий аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдэд танилцуулга хийж, хэлэлцүүлсэн. 2008 оны 10 дугаар сарын байдлаар төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдүүлэх талаар Сангийн яамнаас Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-д хүсэлт тавьсан байна.

б/ Баян-Өлгий аймгийг орон нутгийн телевизтэй болгоход дэмжлэг үзүүлэх асуудлыг судлах.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Баян-Өлгий аймгийн төв Өлгий суманд телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид хуулийн дагуу үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2008 оны 10 дугаар сарын байдлаар тус аймагт нийтдээ 3 аж, ахуйн нэгж, байгууллага казак хэлээр телевизийн үйлчилгээ явуулах үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2009 – 2011 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулагдан холбогдох яам агентлаг, төрийн бус байгууллагуудаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэгдхэд бэлэн болоод байна.

Уг төсөлд Үндэсний хөтөлбөрийн 2.2.5.2 дахь заалт “ Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орон нутгийн харилцаа, холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгслийг зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт- эрх зүйн арга хэмжээ авна “ гэсэн зорилтын хүрээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргахаар тусгагдсан.

Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах үүднээс төрийн байгууллагуул тэр дундаа хөдөө орон нутгийн байгууллагууд цахим хуудас нээх, мэдээллийн самбар ажиллуулах түүнийгээ цаг тухай бүрт шинэчлэн ажиллуулах шаардлагатай байна.

Мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хууль юм.

Төрийн нууцын тухай хуулиар 59 зүйлийн мэдээллийг төрийн нууцад хамруулан нэг бүрчлэн нэрлэн заасан. Байгууллагын нууцын тухай хуулиар тухайн байгууллага нууцаа өөрөө тогтоож, нууц мэдээллийг хамгаалах журам батлах үүрэг хүлээлгэсэн нь хүний мэдээллийн эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж байна.

Цаашид төрийн нууцад хамруулах мэдээллийг нууцлах шаардлагатай эсэхийг үнэлж, нууцлах мэдээллийг аль болох цөөрүүлэх байгууллагын нууцад хамаарах мэдээллийг хуулиар нэрлэн тогтоох шаардлагатай байна.